

**СОНГОДОГ ГЕОПОЛИТИКИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ***К.Дэмбэрэл\**

*“Үндэснийхээ газар зүйг мэднэ гэдэг бол тууний гадаад бодлогыг мэднэ гэсэн үг”. Наполеон Бонапарт*

“Геополитик” хэмээх ойлголтын агуулгыг тодорхойлох олон тооны оролдлого байсаар ирсэн. Энэ ойлголт нь өнөөг хүртэл судлаачдын дунд маргааны томоохон “бай” болсон хэвээр байна. Учир нь түүнийг нэг хэсэг нь шинжлэх ухаан, нөгөө хэсэг нь судалгааны объект, бүр зарим нь олон улсын харилцааны практик алхмын нэг хэмээн ч үзсээр байна. Өөрөөр хэлбэл, гадаад дотоод асуудлыг шийдэх түгээмэл арга хэмээн үзэж буй. Зарим нь бүр геополитик гэдэг нь утга, ач холбогдлоо алдсан түүний үндсэн дээр бий болсон концепци нь зөвхөн “цэцэрхэхээ” өөр юмгүй зүйл хэмээн үзэцгээж байгаа. Дээрхээс харахад олон янзын тайлбар байгаа нь ч өөрөө судлах шаардлагатайг харуулж байна. Нэг тогтсон, хэвшсэн ойлголт байхгүй байна гэдэг нь асуудал эцэслэн “нэг талдаа болоогүй” гэсэн үг.

Энэ чиглэлд олон нийтэд цэгцтэй ойлголт өгөх, түүний мөн чанар, тухайлбал, сонгодог геополитикуудын үзэл санааг хүргэх нь чухал. Учир нь өнөөдөр хүн бүхэн л геополитик ярих болсон нь учир дутагдалтай юм. Бидэнд өдий хүртэл мэдэгдэхгүй шахам байсан сонгодог геополитикуудын бүтээлүүд, түүгээр дамжсан үзэл санааг энэ тэргүүнд гаргаж тавих нь зүйтэй гэж үзлээ. Хэдийгээр геополитик хэмээх нэр томъёо нь улс төрийн хэллэгт өргөн дэлгэр хэрэглэгддэг ч шийдэх асуудлууд нь хэвээр байгаа. Геополитикийн судалгаа хоцрогдсоор ирсэн нь энэ талын мэдлэгийн хүрээг тийм хэмжээгээр орхигдуулахад хүргэлээ. Тэр ч утгаараа орчин үеийн дэлхий дахины бодит байдлыг тоймлон тогтоож, хэтийн төлвийг тогтооход мэдээж хүндрэл учруулж байна гэсэн үг.

Анхны энгийн бөгөөд түгээмэл тодорхойлолтоор бол геополитик гэдэг нь газар зүйн ямар орчинд их гүрний ямар бодлого хэрэгжиж буйн харилцан холбоо, харилцан хараат байдлын тухай судалгаа аж. Уламжлалт зарим нэгэн ойлголтоор бол геополитик нь улс төрийн реализмын нэг салаа мөчир. Ер нь улс төрийн реализм нь олон улсын харилцааг “улс хоорондын хүчний харилцаа”<sup>1</sup> ч гэж тодорхойлдог.

“Геополитик гэдэг нь газар зүйг өргөн дэлгэсэн ойлголт биш бүр тодруулбал “улс төрийн газар зүй ч бус” харин газар зүйн хүчин зүйлийн нөлөөтэйгээр түүхэн үйл явдлыг улс төрийн хувьд удирдах үйл явц” хэмээн зарим онолчид тэмдэглэсэн байдаг. Үүнийг Д.А.Милютин, Г.А.Леер, А.Е.Снесарев нарч зөвшөөрсөн байдаг. “Геополитик гэдэг бол хүчээ зохион байгуулах гэсэн үг”<sup>2</sup> хэмээн АНУ-ын Пенсильванийн

\* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

их сургуулийн профессор Рэндалл Коллинз бичсэн байдаг. Ихэнхи судлаачид газар зүй, улс төр, эдийн засаг, цэрэг, экологи, хүн ам зүй, соёл зэргийг геополитикийн үндсэн хүчин зүйлүүдэд оруулж үздэг. Геополитикийг олон улсын харилцаа, дэлхийн бодлогын талаархи судалгааны нэг чиглэл хэмээх авч үзэх нь илүү бодитой гэж үздэг судлаачид<sup>3</sup> ч бий.

Бүр зарим судлаачид геополитикийг “сайн боловсруулсан мастер төлөвлөгөө” /Р.Страус-Хюпе/ хэмээн энгийнээр тайлбарласан тохиолдол ч бий. Бодит байдал дээр бол геополитик нь өөрийн онолтой, үндсэн ойлголтуудтай, судалгааны арга зүйтэй, судлах зүйлтэй “нийгмийн шинжлэх ухаан”<sup>4</sup> юм. Гол судлах зүйл нь геополитикийг бодит үзэгдлийн хувьд нь авч судалдаг. Геополитикийн шинжлэх ухааны судлах зүйлийг олон янзаар тодорхойлсон байдаг. Энэхүү олон талт тодорхойлолт нь түүхэн нөхцөл байдлаас урган гарсан ба түүнчлэн геополитик нь дэлхийн бодлого, засаглалын асуудал, голлох үзэл суртал зэрэгтэй нягт холбоотой нь ийм байдал хүргэжээ. Олон салбарт хамааралтай байдал нь геополитикийн судалгаанд газар зүй, түүх, хүн ам зүй, стратеги судлал, угсаатан судлал, шашин судлал, экологи, цэрэг байлдааны урлаг, үзэл суртлын түүх, социологи, улс төр судлал гэх зэргийг цогцоор нь авч үзэхэд хүргэж байна. Геополитикийн үндсэн ойлголтууд гэвэл: геостратегийн бүс, геополитикийн бүс, эвсэл улсууд, бамбай улс, геополитикийн холбоотон, их гүрэн, хүчний төв, туйл, халз өрсөлдөөн, тэргүүн шугам г.м.

Геополитик хэрхэн хөгжсөн, түүний хөгжилд ямар хүчин зүйл нөлөөлсөн, түүний бусад шинжлэх ухаантай хэрхэн холбоотой, түүний ямар үзэл санаанууд нь илүү үр ашигтай бөгөөд бодит үйл явцын шинжилгээнд ашиглах зорилгоор анхаарч байв гэдэгт бүрэн дүүрэн хариулах нь энэ талын судалгаа хийдэг судлаачдын үүрэг билээ.

Өнөөгийн геополитикийн зарим нөхцөл байдлыг судлаачид маань тайлбарлахдаа ерөнхийдөө өнгөрсөн үеийн, тухайлбал, сонгодог геополитикийн онолд тулгуурлан тайлбарласаар байна. Ийнхүү эхний ээлжинд сонгодог геополитикийн түүхэн хөгжлөөс хэсэгчлэн авч ямар түүхэн үе шаттай байсныг өгүүлье.

Геополитикийн түүхийг шинжлэх ухааны талаас нь судлахдаа 2 үндсэн аргыг голлон хэрэглэдэг. Нэгдүгээр арга нь геополитикийн судалгаанд, тухайлбал, америкийн, германы, оросын, францын геополитикийн судалгаа гэх зэргээр авч үздэг. Хоёрдугаар арга нь геополитикийн хөгжлийн бүхий л үе шатыг сонгодог буюу империалист, ревизионист, хүйтэн дайны, дэлхийн шинэ дэг журмын гэх мэтээр ангилсан байдаг. Эдгээр хоёр аргуудад эерэг ч, сөрөг ч талууд бий. Ерөнхийдөө бол “бид эдгээр аргын үр дүнд геополитикийг шинжлэх

ухаан гэхээсээ илүү улс төр-соёл, эсвэл түүх-улс төрийн үзэгдэл маягаар хүлээн авахад хүргэж буй”<sup>5</sup> тал анзаарагдаж байна.

Ингээд сонгодог геополитикийн талаар товч өгүүлбэл:

XIX-XX зууны зааг дээр олон улсын харилцааны судалгаанд орж ирсэн шинэ чиглэл бол геополитикийн судалгаа байлаа. Олон улсын харилцааны тухай уламжлалт ойлголт нь газар нутаг, суверенитет буюу аливаа улсын бие даасан байдал, улсын аюулгүй байдал гэсэн гол гурван зүйл дээр үндэслэгдэж байсан. Уламжлалт геополитикийг “аливаа улс нь физик-газар зүйн, байгалийн, нөөцийн, хүн амын болон бусад үзүүлэлтээрээ, өөрийн гэсэн давтагдашгүй өнгөн төрхтэй, өөрийн санаа зориг, сонирхлыг гол болгосон өвөрмөц төрлийн газар зүйн эсвэл газар нутаг, орон зайн цогцос” хэмээн үздэг. Аливаа ард түмэн, төр улсын улс төрийн амьдрал ба газар зүйн орчин хоёр хооронд нягт нарийн холбоо байдаг тухай үзэл санаа эртнээс байсаар ирсэн. Энэ үзэл тодорхой үе шатыг туулж ирсэн нь геополитикийн үзэл санааны хөгжлийн үе шат юм. XVIII зуунд орчин үеийн газар зүйн ухааныг үндэслэгчдийн нэг, францын гүн ухаантан, улс төр судлаач Ш.Л.Монтескье ч дээрх үзлийг үргэлжлүүлэгчийн нэг байлаа.

XIX зууны сүүл гэхэд нийгмийн шинжлэх ухаанд үүссэн асуудлыг газар зүйн үүднээс тайлбарлахыг оролдох үзэгдэл өргөн тархсан нь геополитикийн үүслийн шууд урьдчилсан нөхцөл болсон. Гадаад бодлогын үзэл санааны энэхүү чиглэлийн анхдагчид бол германы газар зүйч Ф.Ратцель /1844-1904/, шведийн эрх зүйч, парламентийн гишүүн Р.Челлен /1846-1922/ нар юм. Харин Р.Челленийг “геополитик” хэмээх нэр томъёог шинжлэх ухааны хэллэгт анх оруулсан хэмээн үздэг. Тэрээр “хүчтэй улс байгуулах зорилгоор удирдлагын системийг судлаж байхдаа 1916 онд улс төрийн бодлогын харилцан нөлөө бүхий өөр хоорондоо нягт холбоо бүхий таван элемент /хэсэг/ болох эдийн засгийн бодлого, хүн ам зүйн бодлого, нийгмийн бодлого, улс төрийн зураг зүйн бодлого, геополитикийг уялдуулан нэгэн цогц болгох нь зайлшгүй” гэсэн дүгнэлтэд хүрсэн. Ф.Ратцель “орон зай гэдэг бол улс төрийн хүч” хэмээн томъёолсон. Тэрээр бичихдээ “орон зай гэдэг нь зөвхөн аль нэг улсын газар нутаг бус харин түүний хүчний чадавхийн чухал хэсэг” гэжээ. Мөн “орон зайн мэдрэмжтэй ард түмэн л агуу байдаг” гэсэн байна.

Геополитикийн судалгааны түүхэнд английн газар зүйч, улс төрч Х.Маккиндер /1861-1947/ “эх газрын орон зайн тодорхой хэсгийг хянадаг улс бусдыг бодвол давуу талтай” гэсэн санааг дэвшүүлснээрээ онцгой байр суурийг эзэлдэг. 1904 онд “түүхийн газар зүйн тэнхлэг” илтгэлдээ “дэлхийн түүх, улс төрийн бодлогын тэнхлэг бүс нь Евразийн дотоод орон зай” хэмээн тэмдэглэсэн. Түүний бодлоор бол “энэ бүсэд

ноёрхлоо хангаж чадсан улс дэлхийд ноёрхлоо тогтоохын төлөө өрсөлдөж чадах” аж. Энэ санаагаа үргэлжлүүлэн 1919 онд бичсэн “Ардчилсан үзэл ба бодит байдал” номондоо “Дорнод Европт хэн ноёрхож байна тэр Хартлэндэд ноёрхно. Хэн Хартлэндэд /Еврази/ ноёрхож чадна тэр Дэлхийн аралд /Европ, Ази, Африк/ ноёрхоно. Хэн Дэлхийн аралд ноёрхож чадна тэр дэлхийг ноёрхоно” гэсэн томъёоллоо гаргасан. Х.Маккиндерийн байр суурь бол тухайн үед Их Британий сонирхлыг илэрхийлж байсан ба тэрээр эх газрын улсууд болох Герман, Орос хоёрыг хүчирхэгжихээс айж байсан төдийгүй тэдгээрийг холбоотон болохоос эмээж байсан. Х.Маккиндер дэлхийн I дайныг хүртэл Оросыг бодвол Герман нь Их Британий хувьд илүү хорлонтой хэмээн үзэж байлаа. Дайны дараагаар тэр “бамбай бүс” гэсэн томъёоллоор Зүүн Европт Орос, Германыг заагласан “бамбай улс” байгуулах, тэгснээр тэдгээрийн аль алиныг гол бүсэд ойртуулахгүй байлгах давхар санааг агуулсан. Х.Маккиндерын дүгнэлтэд Оросын сонгодог геополитикч, генерал А.Е.Снесарев онолын нөлөө үзүүлсэн. А.Е.Снесарев “Дундад Ази” хэмээх бүсэд “Оросын Түркестан, Хятадын Түркестан, Энэтхэг, Афганистан, Иран, Түвдийг” оруулж томъёолсон. Тэрээр энэ “Том Дундад Азийг” дэлхийн бодлогын түлхүүр хэмээн<sup>6</sup> нэрлэсэн.

Х.Маккиндер ХХ зууны II хагасын дэлхийн улс төрийн хөгжлийн хандлагыг нэлээд дөхүү тодорхойлсон. Гэхдээ өөрийн урьдын геополитикийн үзэл санаагаа эргэн харсан. Тэрээр Хойд Атлантикийг “дэлхийн тулгуур цэг Газар дундын далай” хэмээн үзээд, түүний эрэг хавийн улсууд нь Хартлэндэд ноёрхож буй улстай хүчээ тэнцвэржүүлэх боломжтой хэмээн үзсэн. Энэ нь НАТО-гийн эхлэл ч байсан хэмээн судлаачид тодорхойлсон байдаг.

Германы геополитик нь Их Британий нэгэн адил өөрийн гадаад бодлогын чиглэлд онолын үндэслэл өгөхийг оролдсон ба тухайн үеийн Германы гадаад бодлого нь нээлттэй эзлэн түрэмгийлэх шинжтэй байсан ба геополитик нь ч тийм шинжтэй байлаа. Ф.Ратцель дарвинизмыг гол зарчмаа болгон “өөрийн газар нутгаа өргөжүүлж буй улс л амьдрах чадвартай” хэмээн үзэж байсан. Үүнийг нь дайны дараагаар германы геополитикийн гол хүн болсон К.Хаусхофер /1869-1946/ үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Тэрээр “амьдралын орон зай” хэмээх ойлголтыг оруулж ирсэн ба түүнийг өргөжүүлэх нь их гүрний статусын төлөө өрсөлдөж буй аль ч улсын оршин тогтнох нөхцөл хэмээжээ. Эх газрын болон далайн улсуудын сөргөлдөөн зайлшгүй гэж үзээд эх газрын Германы №1 дайсан бол Их Британи гэж тодорхойлжээ. Германы “амьдрах орон зайг” дорно зүгт өргөтгөх боломжтойг олж харсан ч Орос, Германыг холбоотон байлгах тал дээр байсан. Мөн Алс Дорнодын, тухайлбал, Япон, Номхон далайн талаар ч сонирхон судалдаг байв. Түүний “Хил хязгаар, түүний газар

зүйн болон улс төрийн ач холбогдол” /1927/, “Геополитик дахь пан үзэл” /1931/, “Статус-кво ба дэлхийн шинэчлэл” /1939/, “Эх газрын эвсэл” /1941/ зэрэг бүтээлүүд нь геополитикийн талаар нэлээд өргөн ойлголтыг бий болгосон. “Геополитик хэмээх нэр нь тийм ч муухай зүйл биш зөвхөн Герман нь дэлхийн хоёр том дайнд оролцоходоо өөрийн үйл ажиллагааг зөвтгөх гэж түүнийг ашигласан учраас ингэж ойлгогдоход хүрсэн”<sup>7</sup> хэмээн Германы “геополитикийн эцэг” К.Хаусхофер бичсэн байдаг. Дунайгаас эхлэн Кавказаар дамжин Алтайн уулсыг хамран Манжуурт хүрсэн байгалийн том хонгилыг ургамлын аймаг, цаг уур, газар зүйн тогтоцын хувьд нэгэн систем<sup>8</sup> хэмээн авч үзэх боломжтой. Оросууд зүүн зүгт газар нутгийн тэлэлт хийх болон Хятадууд баруун зүгт газар нутгийн тэлэлт хийх хооронд “тодорхой зурвас” гарсан үндсэн нөхцөл байдал, тэр нь өнөөгийн Төв Азийн бүс нутгийг аль хэсэгтээ хамарч байсан аль хэсэгтээ хамрахгүй байсан эсэхийг нарийн тодорхойлон авч үзэх нь арай шинжлэх ухаанч болно.

Америкийн геополитикийн судалгааны эцэг хэмээн үздэг хүн бол адмирал, түүхч А.Мэхэн /1840-1914/ Их Британи, Германы геополитикийн судалгаанаас түүний онцлог нь гэвэл “аливаа улсын хүчний чадавхийн үндэс нь далайд ноёрхох” хэмээн үзсэн. Тэрээр “Америк нь өөрийн газар зүйн байршлаа ашиглан хоёр далайн гол гол зам дээр хяналтаа тогтоох нь түүнд эх газрын улсуудын өмнө давуу байдал бий болгоно” хэмээн үзэж байсан дүгнэлт өнгөрсөн зуунд бараг батлагдсан. XX зууны II хагаст геополитикийн судалгааны төвүүд АНУ-д төвлөрөх болсон.

XX зууны дунд үеийн америкийн геополитикт Н.Спайкмен /1893-1943/ онцгой байр суурийг эзэлдэг. Түүний Х.Маккиндерээс ялгаатай нь гэвэл дэлхийд ноёрхох гол түлхүүрийг Хартлэнд бус харин Римлэнд хэмээн үзсэн. Н.Спайкмены ойлголтоор Римлэндэд евразийн өмнөд эрэг хавийн “хавирган сар” хэлбэртэй бүс нутаг, өөрөөр хэлбэл, Европын тэнгисийн эрэг хавийн улсууд, Ойрхи Дорнод, Энэтхэг, Зүүн Өмнөд Ази, Хятадыг хамарсан бүс байх аж. Үнэхээр энэхүү бүс нь Европыг баруунаас зүүн хүртэл хамраад түүнд хяналтаа тогтоож чадсан хэн боловч багагүй давуу тал олж авна. Ийнхүү Х.Маккиндерийн томъёоллыг Н.Спайкмен өөрийн томъёоллоор сольсон. Үүнд: Римлэндэд ноёрхогч нь Евразид ноёрхож чадна, евразид ноёрхогч нь дэлхийн хувь заяаг шийднэ. Түүний төсөөллөөр АНУ-ын газар зүйн байрлал нь Хартлэндийн хувьд ч Римлэндийн хувьд ч түүнд ихээхэн ач холбогдолтой аж. АНУ нь Римлэндийн хоёр үзүүрт нэгэн зэрэг хандаж чадах ба хойд туйлаар дамжин Хартлэндэд хүрч чадах, тийнхүү Европт бүхэлд хүчний тэнцвэрийг хянах боломжтой. Бүр дэлхийн II дайны үед Н.Спайкмены дэвшүүлсэн концепци нь АНУ-

ын гадаад бодлогыг дэлхийн баруун хагасаас гадагш чиглэсэн улс төрийн үйл явцад идэвхитэй оролцоход чиглэсэн бодлогыг онолын хувьд үндэслэсэн. Н.Спайкмены үзэл цаашдаа дэлхийг геостратегийн ба геополитикийн бүсүүд болгон хуваасан америкийн өөр нэгэн геополитикч С.Б.Коэны концепцид шингэж хөгжсөн. Геостратегийн бүс гэдэг нь түүнийхээр бол дэлхийн улс төр, эдийн засагт тодорхойлогч үүрэгтэй бүсүүд. С.Коэн тийм бүсэд зөвхөн хоёр бүсийг хамруулсан. Үүнд: далайн худалдаанаас хамааралтай тэнгисийн гүрнүүд болон евразийн эх газрынхан. Тэнгисийн гүрнүүдийн гол цөм нь дэлхийн гол гурван далай болох Атлант, Номхон, Хойд мөсөн далайд шууд гарах гарцтай АНУ өөрөө юм. Евразийн эх газрын гол амин судас нь Оросын аж үйлдвэрийн бүс, хуучин ЗХУ-ын Европын хэсэг, Урал, Баруун Сибирь, Хойд Казахстан, Баруун болон Хойд Европын далайн эрэг орчмын улсууд нэгдүгээр бүсэд, Хятад нь хоёрдугаар бүсэд багтаж болох талтай. Хэдий тийм ч тэдгээр нь хязгаар нутгийн шинжтэй байх болов уу. С.Коэны геополитикийн энэхүү концепци нь “хүйтэн дайны” үеийн хоёр туйлт дэлхийн улс төрийн бодит байдлыг тусгаж байсан гэдгийг хялбар ойлгож болох юм. “Хүйтэн дайны” үед дэлхийн олонхи бүсэд геополитикийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой байв. Харин түүний төгсгөл нь юуны өмнө харьцангуй тогтвортой байсан бүсүүдэд тогторгүйжилт бий болгон геополитикийн хоосон орон зайг зохих хугацаанд бий болгоод авсан. Энэ байдал геополитикийн судалгаанд ихээхэн түлхэц өгсөн.

## ДҮГНЭЛТ

Геополитикийг шинжлэх ухаан гэдэг талаас нь судлахдаа шинжлэх ухааны хөгжлийн ямар нэг онолд тулгуурлах нь зүйтэй. Тэгж тулгуурлах онолууд ч байгаа зөвхөн сонголт хийх л шаардлагатай. Загварчлах ойлголтууд нь геополитикийн хөгжлийг нийгэм, улс төрийн түүхийн үүднээс, янз бүрийн үе шатуудад шинжлэх ухааны хөгжлийг үндсэн чиглэлүүдтэй нь холбогдуулан авч үзэх боломжийг олгож байна. Гэхдээ энэ загварчлах арга нь нэг загвараас нөгөөд шилжихдээ уялдаа байдаггүй энэ нь геополитикийн хөгжилд нарийвчилсан шинжилгээ хийх боломж өгөхгүй байгаа. Тийм нарийвчилсан шинжилгээг зарим судлаачдын<sup>9</sup> дэвшүүлсэн эрдэм шинжилгээний хөтөлбөрийн аргачлалын үндсэн дээр хийх боломжтой. Хэдийгээр энэ нь геополитикийн шинжлэх ухааны хөгжлийн судалгааг шинэ түвшинд гаргаж байгаа хэдий ч судлаачид загварчлалын тухай ойлголтоос татгалзаагүй байгаа. Эрдэм шинжилгээний хөтөлбөрийн аргачлал нь дараахи зорилтуудыг шийдэхэд нэлээд дөхөмтэй болж байна. Үүнд: эрдэм шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд геополитикийн онолуудыг нэгтгэх, өрсөлдөж буй

хөтөлбөрүүдийг онцгойлон гаргах, асуудлыг задлан шинжлэх замаар геополитикийн хөгжлийн хандлагыг ажиглах, геополитик бүрэн гүйцэд шинжлэх ухаан болсон үеийг тодорхойлох, эрдэм шинжилгээний илүү ирээдүйтэй хөтөлбөрийг тодруулах, геополитикийн онолын орчин үеийн байдалд дүгнэлт өгөх явдал.

Өнөөгийн геополитикийн шинжлэх ухааны хөгжлийн талаархи судалгааг танин мэдэхүйн үүднээс ч, өөрсдийгөө бүрэн таних талаасаа ч түлхүү явуулах нь хэрэгтэй.

Геополитик нь бодит зүйлийн хувьд нийгэм-түүхийн бодит байдлын зүй тогтол, үзэгдлийн хүрээ, түүний үндэс нь тухайн орон зайд /хуурай газар, ус, агаарын/ нөөц төвлөрүүлэх, хүч хуримтлуулах, түүнчлэн энд хяналтын төлөө хүний хамтын нийгэмлэгийн өрсөлдөөний замаар бий болсон бүх талын хяналт мөн.

Дэлхийн улс төрийн газрын зураг “үндсээрээ” өөрчлөгдсөн, өөрчлөгдөж байгаа, олон улс орон тусгаар улс болон бие даасан, газар нутаг, нийгмийн, эдийн засгийн, хүн ам зүйн, экологийн зөрчлүүд асар хурдацтай өсөн нэмэгдэх болсон, үүнээс үндэслээд улс төрийн сонгодог онолууд үүссэн нөхцөл байдлаас гарах гарцад даацтай хариу өгч чадахгүй байгаа зэрэг нь хурдтай хөгжиж буй геополитикийн шинжлэх ухаан руу илүү ихээр хандах хандлагыг бий болгож байна.

### ИШЛЭЛ, ЗУУЛТ

1. Цыганков П.А. Международные отношения. М., 1996, с.157.
2. Р.Коллинз. Геополитик ба урт хугацааны түүхэн өөрчлөлт., //Время мира. Вып.1, Новосибирск, 2000., с.285//
3. Ланцов.С.А. Мировая политика и международные отношения. Санкт-Петербург., 2000. С.15.
4. Анна Изгарская. Геополитикийн үзэл санааны хөгжлийн нийгэм-философийг өөрчлөн сайжруулах нь. /Время мира. Вып.3, Новосибирск, 2003., с.265-287./
5. Анна Изгарская. Геополитикийн үзэл санааны хөгжлийн нийгэм-философийг өөрчлөн сайжруулах нь. /Время мира. Вып.3, 2003., с.265-287./
6. Төв Азийн геополитик ба Монгол Улс. УБ., 2005.
7. К.Хаусхофер. О геополитике. М., 2001.С.23.
8. Мөн тэнд.
9. Лакатос.И. Фальсификация и методология научно-исследовательских программ. М., 1995.